



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

*Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит*

Аудитын код: **ДОА-2021/152/СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Гэрээт аудитор: О.Эрдэнэтуяа

Утас: 7000-3775, khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар

Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3.Аудитын тайлан.....	11
3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	11
3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ	11
3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ	11
3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ.....	12
3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	12
3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ	13
3.7. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ	13
3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ	14
3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14
Залруулсан алдаа.....	14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	14
3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД.....	14
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	15

1.Хараат бус аудиторын дүгнэлт



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.24 № 180

танай _____-ны № _____-т

ХЭРЛЭН СУМЫН 15 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д.ОТГОНБАЯР ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө дүгнэгдээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

011021260

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	31,728,489.40	33,825,789.40
35	БАРАА МАТЕРИАЛ	31,728,489.40	33,825,789.40
354	Хангамжийн материал	31,728,489.40	33,825,789.40
35410	Бичиг хэргийн материал	35,000.00	35,000.00
35470	Бусад хангамжийн материал	31,693,489.40	33,790,789.40
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	945,992,554.86	924,088,875.83
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	945,992,554.86	924,088,875.83
392	Биет хөрөнгө	906,796,554.82	884,683,042.42
39201	Барилга, байгууламж, орон сууц	883,593,473.51	883,593,473.51
39202	Хуримтлагдсан элэгдэл	(29,806,321.89)	(46,808,951.37)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	33,599,096.30	38,847,596.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	(8,980,738.68)	(14,354,946.72)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,594,231.60	15,594,231.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,929,864.09)	(6,517,679.21)
39214	Бусад үндсэн хөрөнгө	21,813,533.00	21,813,533.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,086,854.93)	(7,484,214.69)
39301	Програм хангамж	770,000.00	1,140,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(153,999.96)	(314,166.59)
39303	Бусад биет бус хөрөнгө	38,580,000.00	38,580,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	977,721,044.26	957,914,665.23
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	977,721,044.26	957,914,665.23
51	Засгийн газрын хувь оролцоо	977,721,044.26	957,914,665.23
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	38,580,000.00	38,580,000.00
51101	Өмч: - төрийн	38,580,000.00	38,580,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	938,608,318.75	918,801,939.72
51210	Өмнөх үеийн үр дүн	938,608,318.75	938,608,318.75
51220	Тайлант үеийн үр дүн		(19,806,379.03)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	532,725.51	532,725.51
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	977,721,044.26	957,914,665.23

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	374,619,419.00	331,970,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	59,764,319.00	5,548,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	125,000.00	300,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	125,000.00	300,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	125,000.00	300,000.00
121	Хөрөнгийн орлого	59,639,319.00	5,248,500.00
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	59,639,319.00	5,248,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	314,855,100.00	326,422,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	300,373,100.00	314,881,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	300,373,100.00	314,881,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	14,234,500.00	11,540,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	14,234,500.00	11,540,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	336,254,463.44	351,777,079.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	336,254,463.44	351,777,079.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	334,067,104.44	339,345,169.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	224,625,900.00	245,361,964.00
210101	Үндсэн цалин	202,492,122.00	194,699,731.00
210102	Нэмэгдэл	2,570,710.00	27,337,566.00
210104	Урамшуулал	19,563,068.00	23,324,667.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,078,300.00	30,610,700.58
210201	Тэтгэврийн даатгал	19,093,300.00	20,963,443.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,246,200.00	2,350,569.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,797,000.00	1,880,416.00
210204	Ажилгүйдлийн даатгал	449,200.00	569,568.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,492,600.00	4,846,704.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,947,192.00	9,835,525.88
210301	Гэрэл, цахилгаан	4,515,452.00	2,452,863.00
210302	Түлш, халаалт	2,055,900.00	5,506,662.88
210303	Цэвэр, бохир ус	4,375,840.00	1,876,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,685,811.00	2,272,930.00
210401	Бичиг хэрэг	506,660.00	319,300.00
210402	Тээвэр, шатахуун	1,598,851.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	495,000.00	188,300.00
210404	Ном, хэвлэл	-	50,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	350,350.00	480,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	734,950.00	735,230.00
2105	Нормативт зардал	41,397,850.00	21,385,170.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	100,000.00	159,600.00
210502	Хоол, хүнс	41,297,850.00	21,225,570.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	159,650.00	1,100,000.00
210604	Урсгал засвар	159,650.00	1,100,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	590,000.00	240,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,462,401.44	28,538,879.03
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00	250,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	475,000.00	766,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,687,401.44	27,522,179.03
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,187,359.00	12,431,909.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	113,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	113,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,987,359.00	12,318,909.54
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,987,359.00	12,318,909.54
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	38,364,955.56	(19,806,379.03)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	38,364,955.56	(19,806,379.03)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	314,855,100.00	326,422,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	314,855,100.00	326,422,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	300,373,100.00	314,881,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	300,373,100.00	314,881,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	14,234,500.00	11,540,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	14,234,500.00	11,540,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	314,855,100.00	326,422,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	314,855,100.00	326,422,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	312,667,741.00	313,990,290.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	224,625,900.00	245,361,964.00
210101	Үндсэн цалин	202,492,122.00	194,699,731.00
210102	Нэмэгдэл	2,570,710.00	27,337,566.00
210104	Урамшуулал	19,563,068.00	23,324,667.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,078,300.00	30,610,700.58
210201	Тэтгэврийн даатгал	19,093,300.00	20,963,443.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,246,200.00	2,350,569.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,797,000.00	1,880,416.00
210204	Ажилгүйдлийн даатгал	449,200.00	569,568.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,492,600.00	4,846,704.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,947,192.00	9,835,525.88
210301	Гэрэл, цахилгаан	4,515,452.00	2,452,863.00
210302	Түлш, халаалт	2,055,900.00	5,506,662.88
210303	Цэвэр, бохир ус	4,375,840.00	1,876,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,208,499.00	2,965,030.00
210401	Бичиг хэрэг	541,660.00	244,700.00
210402	Тээвэр, шатахуун	1,598,851.00	500,000.00
210403	Шүүдан, холбоо, интернэтийн төлбөр	495,000.00	188,300.00
210404	Ном, хэвлэл	171,488.00	150,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	350,350.00	480,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,051,150.00	1,401,330.00
2105	Нормативт зардал	41,997,850.00	22,516,370.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	100,000.00	236,600.00
210502	Хоол, хүнс	41,297,850.00	21,225,570.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	1,054,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,300,000.00	1,100,000.00
210604	Урсгал засвар	1,300,000.00	1,100,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	590,000.00	522,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	410,000.00	282,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	800,000.00	1,078,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00	250,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	828,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,187,359.00	12,431,909.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	113,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	113,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,987,359.00	12,318,909.54
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,987,359.00	12,318,909.54
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	38,580,000.00	532,725.51	938,608,318.75	0.00	977,721,044.26
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	38,580,000.00	532,725.51	938,608,318.75	0.00	977,721,044.26
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	38,580,000.00	532,725.51	938,608,318.75	0.00	977,721,044.26
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	38,580,000.00	532,725.51	938,608,318.75	0.00	977,721,044.26
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	38,580,000.00	532,725.51	938,608,318.75	0.00	977,721,044.26
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-19,806,379.03	0.00	-19,806,379.03
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	38,580,000.00	532,725.51	918,801,939.72	0.00	957,914,665.23

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	329,927,300.00	314,103,290.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	329,927,300.00	314,103,290.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	329,814,300.00	313,990,290.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	248,598,800.00	245,361,964.00
210101	Үндсэн цалин	199,206,600.00	194,699,731.00
210102	Нэмэгдэл	26,321,800.00	27,337,566.00
210104	Урамшуулал	23,070,400.00	23,324,667.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,074,900.00	30,610,700.58
210201	Тэтгэврийн даатгал	21,130,900.00	20,963,443.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,486,000.00	2,350,569.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,988,800.00	1,880,416.00
210204	Ажилгүйдлийн даатгал	497,200.00	569,568.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,972,000.00	4,846,704.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,440,300.00	9,835,525.88
210301	Гэрэл, цахилгаан	2,694,600.00	2,452,863.00
210302	Түлш, халаалт	5,749,500.00	5,506,662.88
210303	Цэвэр, бохир ус	1,996,200.00	1,876,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,021,400.00	2,965,030.00
210401	Бичиг хэрэг	244,700.00	244,700.00
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	188,300.00	188,300.00
210404	Ном, хэвлэл	150,600.00	150,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	480,100.00	480,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,457,700.00	1,401,330.00
2105	Нормативт зардал	33,978,200.00	22,516,370.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	236,600.00	236,600.00
210502	Хоол, хүнс	32,687,400.00	21,225,570.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,054,200.00	1,054,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,100,000.00	1,100,000.00
210604	Урсгал засвар	1,100,000.00	1,100,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	522,400.00	522,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр х	282,400.00	282,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,078,300.00	1,078,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	250,000.00	250,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	828,300.00	828,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	113,000.00	113,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	113,000.00	113,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	113,000.00	113,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	329,927,300.00	314,103,290.46
1310	ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	329,927,300.00	314,103,290.46
131001	Төсвөөс санхүүжих	329,927,300.00	314,103,290.46

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		00.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		00.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		00.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		00.00
131106	Төсвийн урамшуулал		00.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3.Аудитын тайлан

3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Д.Отгонбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 5-наас 2021 оны 02 дугаар сарын 15-ны хооронд Хаан консалтинг аудит ХХК-ийн гэрээт аудитор О.Эрдэнэтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 07 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Бага насны хүүхдийн ялгаатай байдлыг харгалзан өв тэгш хөгжүүлэн өөртөө итгэлтэй хүүхдийг төлөвшүүлэн ажиллана. Хүүхдийн авьяас чадвар болон гоо зүйн хөгжилд дэмжлэг үзүүлнэ.
- Суралцагчдын ялгаатай байдлыг харгалзан тэгш бус байдлыг бууруулах ажлыг хэрэгжүүлэн үр дүнг тооцох
- Онцгой байдлын нөхцөлд хичээл сургалтын үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх, ариун цэвэр, эрүүл ахуйн дадлыг төлөвшүүлж, бэлэн байдлыг ханган ажиллах
- Багш ажилчдыг ажлын байран дээр тасралтгүй хөгжих боломжоор хангах
- Эцэг эх, аж ахуйн нэгж байгууллага иргэдэд, цэцэрлэгийн үйл ажиллагаа, хүүхдийн хөгжлийн мэдээллийг цар тахлын үед цахимаар тогтмол хүргэж эргэх холбоотой хамтран ажиллах
- Сургуулийн насны хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 351,777.0 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 20,587.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 19,806.4 мянган төгрөгөөр буюу 2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	
Авлага	0	0	
Урьдчилгаа	0	0	
Бараа материал	31,728.4	33,825.7	2,097.3
Үндсэн хөрөнгө	945,992.5	924,088.8	-21,903.7
Нийт хөрөнгө	977,721.0	957,914.6	-19,806.4
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	977,721.0	957,914.6	-19,806.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	977,721.0	957,914.6	-19,806.4

Авлага, өглөгийн данс үлдэгдэлгүй байна.

Бараа материал данс 33,825.7 мянган төгрөг болж 2,097.3 мянган төгрөгөөр өссөн нь батлагдсан төсвөөс худалдан авсан аж ахуйн материалаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө данс 924,088.8 мянган төгрөг болж 21,903.7 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлээс шалтгаалжээ. Хөрөнгийн элэгдэл 27,522.1 мянган төгрөг байна.

Үндсэн хөрөнгийн данс нь хөрөнгө оруулалтаар 5,248.4 мянган төгрөгийн компьютер, техник хэрэгсэл, төсвийн худалдан авалт 370.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө актлаагүй байна.

Засгийн газрын оролцоо данс 957,914.6 мянган төгрөг болж, 19,806.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 11,567.1 мянган төгрөгөөр буюу 3.6 хувиар өссөн нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 15,522.6 мянган төгрөгөөр буюу 4.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, хангамжийн материалын зардал бараа үйлчилгээний бусад зардлууд байна. Энэ нь цалин нэмэгдсэн, бараа материалын үнэ өссөн зэргээс шалтгаалсан байна.

3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 436,718.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 436,718.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 106,790.7 мянган төгрөгөөр бууруулж 329,927.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 329,927.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 318,387.0 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 11,540.3 мянган төгрөгийг орон нутгаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 316,862.2 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 9,560.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 326,422.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 314,103.3 мянган төгрөгийг зарцуулж 12,318.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 314,104.3 мянган төгрөг буюу 96 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал зардлыг 3,236.8 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэл 464.2 мянган төгрөгөөр, бараа материалын зардлыг 56.3 мянган төгрөгөөр, хүүхдийн хоолны 8,561.6 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулсан нь Ковид-19 цар тахал гарснаас үүдэн үйл ажиллагаа явуулаагүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ гараагүй байна

3.7. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээлэл байршуулахаас хугацаандаа тайлан, мэдээ, гүйлгээгээ шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчилгүй дүгнэгдсэн байна.

3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,695.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд 3,695.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдаа зөрчил гараагүй.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар татварын нэгдсэн цахим системд бүртгэлгүй худалдан авалт 3,695.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

Татварын нэгдсэн цахим хуудас дахь и баримт системд бүртгэлгүй 3,695.8 мянган төгрөгийн худалдан авалт байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь “анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 5.1.4 дэх “Үнэн, зөв байх”, 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос татвар суутган тооцсон байна. Үүнийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
2020			ДОА-2021/152/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэг		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1 3	Татварын нэгдсэн цахим хуудас дахь и баримт системд бүртгэлгүй 3,695.8 мянган төгрөгийн худалдан авалт	3,695.1	Албан шаардлага өгөх	Эрхлэгч, нягтлан бодогч	Д.Отгонбаяр, Ц.Отгонцэцэг
	ДҮН	3,695.1			